



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/21

Хатан суудал

Г Зөвшөөрөл олгох тухай Г

Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, иргэний хүсэлт зэргийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хатан суудал 5 дугаар багийн нутагт байрлах “Өлзий” дэлгүүрт 1 жилийн хугацаатай тамхи худалдаалах зөвшөөрлийг олгосугай.

2. Дээрх дэлгүүрийг Төрийн сангийн 030700941 тоот дансанд 100 000 (Нэг зуун мянган) төгрөг тушаасан баримтыг үндэслэн Тамхи худалдаалах зөвшөөрлийн гэрчилгээг 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн олгохыг Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (Ж.Цэцэгмаа)-д зөвшөөрсүгэй.

3. Тамхины хяналтын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллахыг “Өлзий” дэлгүүрийн эзэнд даалгасугай.

4. Худалдаа үйлчилгээний цэгт холбогдох хууль тогтоомж, цагийн хуваарийг мөрдүүлэн, хяналт тавьж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч, Цагдаагийн дэслэгч (Г.Эрдэнэбилэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА  О.МӨНХБАТ



642101349